



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ОРА-2026/05-13-ШТА-НА



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Болормаа
Утас: 70355805 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn
Аудитор: Г.Даваасүрэн
Утас: 70357955 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn
Аудитор: Л.Болормаа
Утас: 70355805 Цахим хаяг: bolormaal@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	6
Хүснэгтийн товъёг	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл	7
Үндсэн мэдээлэл.....	10
БҮЛЭГ 1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДСАН ХЭДИЙ Ч НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА.....	11
БҮЛЭГ 2 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭМНЭЛТИЙГ БОЛЗОШГҮЙ АВААРЫН ЗАРДАЛД ШИЛЖҮҮЛЭН ЗАРЦУУЛЖЭЭ.....	20
БҮЛЭГ 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ АЛДАГДСАН БАЙНА.....	29
ДҮГНЭЛТ.....	31
ЗӨВЛӨМЖ.....	32

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/09

Баян-Өндөр сум

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан "Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам"-ын 4.1 дэх хэсэг, 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан "Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Т.Болормаа/-д үүрэг болгосугай.
4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг ахлах аудитор /Т.Болормаа/-д даалгасугай.
5. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Зоригтбаяр/, Баян-Өндөр сумын Засаг дарга /Б.Мөнхбаяр/, Жаргалант сумын Засаг дарга /Ч.Учрал/ нарт зөвлөсүгэй.
6. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2026 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер Б.Буян-Ундрах, ахлах аудитор Т.Болормаа, аудитор Г.Даваасүрэн нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ПҮРЭВЛХАГВА

612501017

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын 2025 оны 05 дугаар сарын 11-
ны өдрийн А/09 тушаалын хавсралт

6117143600
☎ АА0073 9042306

№	Зөрчлийн утга	Хариуцах эзэн	Албан шаардлага	Төлбөрийн акт
1	Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 19,001,700,000 төгрөгийн батлагдсан төсөвтэй 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж дуусгаагүйгээс үүссэн хэмнэлт болон худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 3,846,700,000 төгрөгийн хэмнэлтийг аймгийн болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлсэн байна.	Аймгийн засаг дарга	22,848,400,000	
2	Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дүгнэлтээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан "Мээжийн хишиг" ХХК-ыг аймгийн болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлэх 366,253,100 төгрөгийн гэрээний дүнтэй 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулсан байна.	Аймгийн засаг дарга	366,253,100	
3	Аймгийн болзошгүй аваарын зардлаар "Браун элеватор Монголиа" ХХК-ийн хэрэгжүүлсэн 8 цахилгаан шатны ажлыг зах зээлийн ханшнаас тус бүрийг нь 55,134,770 төгрөгийн өндөр үнэтэйгээр гүйцэтгүүлсэн байна.	Аймгийн засаг дарга	441,078,160	
4	Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 5 ТАХ-ээс чанарын баталгаа 72.1 сая төгрөгийн суутгаагүй, гүйцэтгэгчид санхүүжилтийг бүтэн олгосон байна.	Аймгийн засаг дарга	72,096,559	
5	Аймгийн болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн зарим арга хэмжээний санхүүжилтийн анхан шатны баримт шаардлага хангаагүй байхад санхүүжилтийг олгосон байна. Тухайлбал: • Захиалагч гэрээ байгуулах эрх олгох талаар алба бичгийг гүйцэтгэгчид хүргүүлсэн өдрөөс хойш гүйцэтгэгч захиалагчид үнийн саналаа ирүүлсэн, • Гүйцэтгэгч байгууллагын татвар, нийгмий даатгалын шимтгэлийн тодорхойлолтыг гэрээ байгуулсан өдрөөс хойш захиалагчид ирүүлсэн, • Гүйцэтгэгчээс ирүүлсэн албан бичгүүд он саргүй улсын байцаагчийн дүгнэлтгүй байна.	Аймгийн засаг дарга		
6	Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар Орхон аймгийн цагдаагийн газарт автомашин нийлүүлсэн "Мэнд пирамид" ХХК гэрээнд заасан хугацааг 9 хоног хэтрүүлсэн хэдий ч 1,269,180 төгрөгийн алдангийг суутгалгүй санхүүжилтийг бүрэн олгосон байна.	Баян-Өндөр сумын Засаг дарга		1,269,180
7	Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар Оюу цэцэрлэгийн гадна тохижилтын ажил гүйцэтгэсэн "Уудамбулаг" ХХК гэрээнд заасан хугацааг 6 хоног хэтрүүлсэн хэдий ч 666,000 төгрөгийн алдангийг суутгалгүй санхүүжилтийг бүрэн олгосон байна.	Баян-Өндөр сумын Засаг дарга		666,000

8	Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний хүрээнд Төрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах боломжгүй, ашиг олох зорилготой 3,170,000,000 (Гурван тэрбум нэг зуун далан сая) төгрөгийн 2 төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Баян-Өндөр сумын Засаг даргын төсөвт хамаарахгүй "Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк" ОНӨААТҮГ-т шилжүүлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад тарааж, ашиглуулж байна.	Баян-Өндөр сумын Засаг дарга	3,170,000,000	
9	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 5 төсөл арга хэмжээнээс 56.7 сая төгрөгийн чанарын баталгааг суутгаж аваагүй санхүүжилтийг олгосон байна.	Баян-Өндөр сумын Засаг дарга	56,750,000	
10	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд батлагдсан "Их залуу багт камержуулалт" төсөл арга хэмжээний санхүүжилт 49,828,467 (Дөчин есөн сая найман зуун хорин найман мянга дөрвөн зуун жаран долоон) төгрөгийг Баян-Өндөр сумын Засаг даргын захирамжаар болзошгүй аваарын зардлаас гаргаж, зарцуулсан байна.	Баян-Өндөр сумын Засаг дарга	49,828,467	
11	Болзошгүй аваарын зардлаар хийгдсэн үерийн далан нөхөн сэргээх, суваг шууду засвардлах 29.1 сая төгрөгийн ажлыг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.	Баян-Өндөр сумын Засаг дарга	29,120,000	
12	Болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлсэн "Жаргалант ус дулаан түгээх станц" ОНӨХК-ийн их засварын ажлын урьдчилгаа санхүүжилтийн 60 хувийг гүйцэтгэгчид шилжүүлэх байтал 122,536,000 (нэг зуун хорин хоёр сая таван зуун гучин зургаан) төгрөгийн санхүүжилтийг "Юникорн Менежмент" ХХК-д илүү олгосон байна.	Жаргалант сумын Засаг дарга	122,536,000	
13	"Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг зөрчин 90,000,000 (Ерэн сая) төгрөгийн төсөвт өртөгтэй өвлийн спортыг дэмжих төсөл, арга хэмжээний худалдан авалтыг 5 хувааж, шууд худалдан авалт хийхээр төлөвлөж, зохион байгуулсан байна.	Жаргалант сумын Засаг дарга	90,000,000	
14	Болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлсэн 94,272,220 төгрөгийн өртөгтэй 7 төсөл, арга хэмжээнд сумын Засаг даргын захирамж гаргаагүй, Улсын байцаагчийн дүгнэлт гараагүй байхад 403,631,320 төгрөгийн өртөгтэй 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.	Жаргалант сумын Засаг дарга	497,903,540	
15	Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ээс 5,010.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-ний санхүүжилт олгогдсон ч бүртгэлгүй орхигдсон байна	ОНӨГ-ын дарга	5,010,200,000	
16	Санхүүжилтийн мэдэгдэл олгосон анхан шатны баримтаас 2025 оны 9,10,11,12 сарын 3,697.9 сая төгрөгийн 29 ТАХ-ний анхан шатны баримтыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй.	Аймгийн засаг дарга, ЗДТГ-ын дарга	Хариуцлах тооцуулах алба шаардлага	
Нийт			32,754,165,826	1,935,180

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХТГ	Хот тохижуулах газар
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
УДДТ	Ус дулаан түгээх төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
БТСГ	Биеийн тамир спортын газар
АЗС	Авто замын сан
ЭТС	Эрдэнэт сан
БХС	Байгаль хамгаалах сан
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШХА	Шууд худалдан авалт

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	2025 оны төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 2	Баян-Өндөр сумын ИТХ-р баталсан хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 3	Аймгийн 2025 оны төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 4	Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй ТАХ
Хүснэгт 5	“Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй нийцээгүй ТАХ
Хүснэгт 6	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцээгүй ТАХ
Хүснэгт 7	Эдийн засгийн үр ашиг тодорхойгүй ТАХ
Хүснэгт 8	ХАА-ны үр дүнд бий болсон хэмнэлтийн задаргаа
Хүснэгт 9	Болзошгүй аваарын зардлын төсөв
Хүснэгт 10	ХАА-ны хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөө
Хүснэгт 11	Худалдан авах ажиллагааны үр дүн
Хүснэгт 12	Зөвлөх үйлчилгээ
Хүснэгт 13	Болзошгүй аваарын зардлын гүйцэтгэл
Хүснэгт 14	Цахилгаан шатны үнийн санал
Хүснэгт 15	Тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй жагсаалт
Хүснэгт 16	Гомдол, шийдвэрлэлтийн байдал

Хүснэгт 17	Санхүүжилт олгосон мэдээлэл
Хүснэгт 18	Болзошгүй аваарын зардал Зөвлөх үйлчилгээний олгосон санхүүжилт
Хүснэгт 19	ТАХ-ний хэрэгжилтийн байдал
Хүснэгт 20	ТАХ-ний бүртгэл
График 1	Алсын Хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байдлыг харуулбал
График 2	“Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй нийцсэн байдлыг харуулбал
График 3	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн ТАХ
График 4	Болзошгүй аваарын зардлын өсөлт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны А/173 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөний” дагуу аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх,
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орхон аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын

газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, Хотын захирагчийн алба, “Хот байгуулалт барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ зэрэг холбогдох байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Аудитын арга зүй

Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр,
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”.

Аудитын шалгуур үзүүлэлт

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Болормаа, аудитор Г.Даваасүрэн, Л.Болормаа нар 2026 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

**Аудитын явцад
учирсан хүндрэл,
бэрхшээлүүд**

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

Үндсэн мэдээлэл

Орхон аймгийн ИТХ-ын 2024 оны 03/13 дугаар тогтоолоор 4 эх үүсвэрээс 158,986.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 119,983.2 сая төгрөгийн 234 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын тодотголоор 212,332.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 169,148.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 252 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвт өөрчлөлт оржээ.

Хүснэгт 1 2025 оны төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ

№	ТАХ төрөл	Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/13			Аймгийн ИТХ-ын 2025 оны 03/40		
		ТАХ тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Шилжих хө.ор	55	56,092.4	23,237.7	68	60,667.7	26,933.4
2	Барилга байгууламж	42	53,017.3	20,595.9	55	57,592.6	24,291.6
3	Зөвлөх үйлчилгээ	1	1,661.9	1,661.9	1	1,661.9	1,661.9
4	Тоног төхөөрөмж	12	1,413.2	979.9	12	1,413.2	979.9
5	Шинээр эхлэх хө.ор	137	88,975.80	85,875.80	142.00	137,746.7	131,345.0
6	Барилга байгууламж	22	30,282.30	27,182.30	27	77,386.9	72,651.5
7	их засвар	86	51,225.50	51,225.50	86	52,891.8	51,225.5
8	Тоног төхөөрөмж	29	7,468.00	7,468.00	29	7,468.00	7,468.00
9	Байгаль хамгаалах сан	33	4,622.0	4,622.0	33	4,622.0	4,622.0
10	Шилжих хө.ор	1	129.6	129.6	1	129.6	129.6
11	Шинээр эхлэх хө.ор	32	4,492.4	4,492.4	32	4,492.4	4,492.4
12	Барилга байгууламж	20	4,260.8	4,260.8	20	4,260.8	4,260.8
13	Төсөл хөтөлбөр	12	231.6	231.6	12	231.6	231.6
14	Авто замын сан	5	2,796.00	2,796.00	5	2,796.0	2,796.0
15	Эрдэнэт сан	4	6,499.9	3,451.7	4	6,499.9	3,451.7
	Нийт дүн	234	158,986.1	119,983.2	252	212,332.3	169,148.1

Баян-Өндөр сумын ИТХ-аар хөрөнгө оруулалт болон байгаль хамгаалах сангийн эх үүсвэрээр 10,999.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл арга хэмжээг 9,846.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор 19,034.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 77 төсөл арга хэмжээг 17,881.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгол хийсэн байна.

Хүснэгт 2 Баян-Өндөр сумын ИТХ-р баталсан хөрөнгө оруулалтын ТАХ

ТАХ-ний нэр	ТАХ-тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Шилжих хө.ор	6	2,008.0	860.6	6	2,008.0	860.6
Барилга байгууламж	4	1,685.1	598.7	4	1,685.1	598.7
Төсөл хөтөлбөр	2	322.9	261.9	2	322.9	261.9
шинэ хө. Ор	54	7,982.7	7,982.7	64	16,018.0	16,018.0
Барилга байгууламж	12	1,477.4	1,477.4	15	3,576.3	3,576.3

тоног төхөөрөмж	11	3,688.0	3,688.0	11	4,368.0	4,368.0
Зөвлөх үйлчилгээ	1	300.0	300.0	1	300.0	300.0
Төсөл хөтөлбөр	30	2,517.3	2,517.3	37	7,773.70	7,773.70
Байгаль хамгаалах сан	7	1,008.8	1,003.0	7	1,008.8	1,003.0
Барилга байгууламж	4	868.1	868.1	4	868.1	868.1
Зөвлөх үйлчилгээ	2	40.7	34.9	2	40.7	34.9
тоног төхөөрөмж	1	100.0	100.0	1	100.0	100.0

Харин Жаргалант сумын ИТХ-аар 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 02/31 дугаар тогтоолоор 8,096.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 төсөл арга хэмжээг 7,167.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсныг сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 02/10 дугаар тогтоолоор 8,199.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 54 төсөл арга хэмжээг 7,325.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгон баталжээ.

БҮЛЭГ 1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДСАН ХЭДИЙ Ч НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА.

1.1. **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Орхон аймгийн хөгжлийн төлөвлөгөө, засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэж байна.**

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 03/40 дугаар тогтоолоор 212,332.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 252 төсөл арга хэмжээг 169,148.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, Баян-Өндөр сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор 19,034.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 77 төсөл арга хэмжээг 17,881.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, Жаргалант сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 02/10 дугаар тогтоолоор 8,199.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 54 төсөл арга хэмжээг 7,325.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт 239,566.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 383 төсөл арга хэмжээг 194,355.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгож баталжээ.


Хүснэгт 3 Аймгийн 2025 оны төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ

№	Эх хүүсвэр	ТАХ төрөл	ТАХ тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Шилжих хө. Ор	Аймгийн ОНХО	Барилга байгууламж	55	57,592.6	24,291.7
		Тоног төхөөрөмж	12	1,413.2	979.9
Шинэ хө.ор	Аймгийн ОНХО	Барилга байгууламж	25	26,678.3	21,942.9
		их засвар	86	52,891.8	51,225.5
Шилжих хө. Ор	Аймгийн БХСан	Тоног төхөөрөмж	29	7,468.0	7,468.0
		БХСан	1	129.6	129.6
Шинэ хө.ор	Авто замын сан	Барилга байгууламж	20	4,260.8	4,260.8
		Авто замын сан	5	2,796.0	2,796.0
Шилжих хө. Ор	Эрдэнэт сан	Эрдэнэт сан	4	6,499.9	3,451.7
Шилжих хө. Ор	Баян-Өндөр сум ОНХО	Барилга байгууламж	4	1,685.1	598.7
		Барилга байгууламж	15	3,576.3	3,576.3
Шинэ хө.ор		тоног төхөөрөмж	11	4,368.0	4,368.0

Шинэ хө.ор	Баян-Өндөр сум БХСан	Барилга байгууламж	4	868.1	868.1
		Зөвлөх үйлчилгээ	2	40.7	34.9
		тоног төхөөрөмж	1	100.0	100.0
Шилжих хө. Ор	Жаргалант сум ОНХО	Барилга байгууламж	2	2,520.4	2,570.9
Шинэ хө.ор		их засвар	9	690.4	690.4
		Тоног төхөөрөмж	13	340.0	340.0
Нийт			298	173,919.2	129,693.4

Орхон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн 173,919.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 129,693.4 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 298 төсөл арга хэмжээг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж буй эсэхийг үнэлэхэд дараах байдалтай байна.

График 1 Алсын Хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байдлыг харуулбал:



“Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй 91.3% нийцсэн төсөл арга хэмжээг төлөвлөжээ.

Хүснэгт 4 Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй ТАХ


№	Эх үүсвэр	ТАХ нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Аймгийн хө.ор	Хурдан морь барианы тохижилт хийх	350.0	350.0
2		Ахмадын ордонд чийрэгжүүлэлтийн болон камержуулалтын хэрэгсэл худалдан авах	55.0	55.0
3		Төрийн архивд шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах нөхцөлийг сайжруулах	30.4	30.4
4		Статистикийн хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах	19.5	19.5
5		Хүн ам, орон сууцны завсрын тооллого хийх үйл ажиллагаанд хэрэгцээт тоног төхөөрөмж худалдан авах	20.0	20.0
6		Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаанд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	33.9	33.9

7		Өрхийн тариалалтыг дэмжин хөгжүүлэх зорилгоор хүлэмж худалдан авах	200.0	200.0
8		Аймгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх	105.0	105.0
9		Орон гэргүй иргэдэд гэр худалдан авах	360.0	360.0
10		Сервер шинэчлэх шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	38.6	38.6
11		"Орхон АЗЗА" ТӨХК-т техник худалдан авах	350.0	350.0
12		ГХБХБГ-т байгууллагын болон албаны нууцын хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	28.3	28.3
13	Аймгийн БХСан	Ойн санг гэрээгээр эзэмшдэг 5 нөхөрлөлд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн хүлэмж олгох	50.0	50.0
14		Байгаль орчныг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх зорилгоор камержуулалтын ажил зохион байгуулах зардал	75.0	75.0
15	Баян- өндөр сум хө.ор	Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2,550.0	2,550.0
16		Төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай хүргэх зорилгоор автомашины хэвийн үйл ажиллагааг хангах	120.0	120.0
17		Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын дүрэмт хувцас худалдан авах	36.0	36.0
18		Хойд бүсийн хэмжээнд ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах	650.00	650.0
19		Хурдан морь барианы тохижилт хийх	100.0	100.0
20	Жаргалант сумын хө.ор	Жаргалант угтах хаалгыг шинэчлэн засварлах	130.0	130.0
21		Жаргалант багийн суваргатай толгойд саравч барих ажил	30.0	30.0
22		Дулаан -уул багийн нутаг дэвсгэрт Айргийн хөндийд саравч барих ажил	30.0	30.0
23		Гэр оронгүй зорилтот бүлгийн иргэдэд гэр олгох нэг удаагийн тусламжийн хүрээнд: Иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу гэр худалдан авах	20.0	20.0
24		Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу оёдлын машин худалдан авах	20.0	20.0
25		Өвлийн спортыг дэмжиж мөсөн талбайд хувцас солих өрөө тохижуулах	15.0	15.0
Нийт			5,416.6	5,416.6

Аймгийн ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 03/46 дугаар тогтоолоор “Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г 4 зорилтын хүрээнд 188 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

“Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй хөрөнгө оруулалтын 298 төсөл арга хэмжээг нийцэж буй эсэхийг үнэлэхэд 94% нийцсэн, 6% буюу 18 төсөл арга хэмжээ нийцээгүй байна.

График 2 “Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй нийцсэн байдлыг харуулбал:



Хүснэгт 5 “Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй нийцээгүй ТАХ

Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Аймгийн хө.ор	Сум дундын ойн ангид автомашины гарааш барих	185.0	185.0
	Орон сууцны шинээр баригдаж буй хороололд өндөржилтийн цэг байгуулах.	85.0	85.0
	Хурдан морь барианы тохижилт хийх	350.0	350.0
	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаанд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	33.9	33.9
	Өрхийн тариалалтыг дэмжин хөгжүүлэх зорилгоор хүлэмж худалдан авах	200.0	200.0
	"Орхон АЗЗА" ТӨХК-т техник худалдан авах	350.0	350.0
Баян-Өндөр хө.ор	Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2,550.0	2,550.0
	Төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай хүргэх зорилгоор автомашины хэвийн үйл ажиллагааг хангах	120.0	120.0
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын дүрэмт хувцас худалдан авах	36.0	36.0
	Хойд бүсийн хэмжээнд ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах	650.0	650.0
	Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Шахмал түлш үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	100.0	100.0
	Хурдан морь барианы тохижилт хийх	100.0	100.0
Жаргалант сум хө.ор	Жаргалант угтах хаалгыг шинэчлэн засварлах	130.0	130.0
	Жаргалант багийн суваргатай толгойд саравч барих ажил	30.0	30.0
	Дулаан -уул багийн нутаг дэвсгэрт Айргийн хөндийд саравч барих ажил	30.0	30.0
	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу оёдлын машин худалдан авах	20.0	20.0
	Гэр хорооллын айл өрхийг дэмжих ажлын хүрээнд: Тень худалдан авах	80.0	80.0
	Гэр хорооллын айл өрхийг дэмжих ажлын хүрээнд: Бага оврын агаар сэлгэлт тоног төхөөрөмж худалдан авах	20.0	20.0

Нийт дүн	5,069.9	5,069.9
----------	---------	---------

Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/15 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 4 бүлэг 152 зорилт хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй хөрөнгө оруулалтын 298 төсөл арга хэмжээг нийцсэн эсэхийг үзэхэд 93% буюу 277 төсөл арга хэмжээ нийцсэн, 7% буюу 21 төсөл арга хэмжээ нийцээгүй байна.

График 3 Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн ТАХ



Хүснэгт 6 Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцээгүй ТАХ

Эх үүсвэр	ТАХ-нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Аймгийн хө.ор	“Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-ийн Захиргааны байр барих	3,353.49	605.09
	Сум дундын ойн ангид автомашины гарааш барих	185.0	185.0
	Хурдан морь барианы тохижилт хийх	350.0	350.0
	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаанд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	33.91	33.91
	Өрхийн тариалалтыг дэмжин хөгжүүлэх зорилгоор хүлэмж худалдан авах	200.0	200.0
	"Орхон АЗЗА" ТӨХК-т техник худалдан авах	350.0	350.0
	Ойн санг гэрээгээр эзэмшдэг 5 нөхөрлөлд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн хүлэмж олгох	50.0	50.0
	Байгаль орчныг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх зорилгоор камержуулалтын ажил зохион байгуулах зардал	75.0	75.0
Баян-Өндөр хө.ор	Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	2,550.0	2,550.0
	Төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай хүргэх зорилгоор автомашины хэвийн үйл ажиллагааг хангах	120.0	120.0
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын дүрэмт хувцас худалдан авах	36.0	36.0
	Хойд бүсийн хэмжээнд ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах	650.0	650.0

	Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Шахмал түлш үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	100.0	100.0
	Хурдан морь барианы тохижилт хийх	100.0	100.0
	Жаргалант угтах хаалгыг шинэчлэн засварлах	130.0	130.0
	Жаргалант багийн суваргатай толгойд саравч барих ажил	30.0	30.0
	Дулаан -уул багийн нутаг дэвсгэрт Айргийн хөндийд саравч барих ажил	30.0	30.0
Жаргалант хө.ор	Гэр оронгүй зорилтот бүлгийн иргэдэд гэр олгох нэг удаагийн тусламжийн хүрээнд: Иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу гэр худалдан авах	20.0	20.0
	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу оёдлын машин худалдан авах	20.0	20.0
	Гэр хорооллын айл өрхийг дэмжих ажлын хүрээнд: Тень худалдан авах	80.0	80.0
	Гэр хорооллын айл өрхийг дэмжих ажлын хүрээнд: Бага оврын агаар сэлгэлт тоног төхөөрөмж худалдан авах	20.0	20.0
Нийт дүн		8,483.41	5,735.01

1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэдийн оролцоог хангаагүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл арга хэмжээг төлөвлөжээ.

Аймгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 14,396.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 10,574.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 16 ТАХ-г ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж тодорхойгүй хөрөнгө оруулалтыг төлөвлөжээ.

Хүснэгт 7 Эдийн засгийн үр ашиг тодорхойгүй ТАХ

ТАХ-ний нэр	Эх үүсвэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Эрдэнэтэд үйлдвэрлэв барилга барих	Аймгийн хө.ор	3,583.0	3,583.0
Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих		3,353.5	605.1
Хөв цөөрмийн ажлыг дуусгах /Эрдэнэ баг. Бүрэнбүстийн овооны хажууд/		284.8	170.9
Эрдэнэ баг. Эрчим хүчний өндөр хэмнэлтэд 37-н айлын Хайбрид гарден хотхоны гадна тохижилт хийх, инженерийн дэд бүтцийн ажил		1,987.8	1,027.6
Зэст баг. Орон сууцны 1-р хорооллын 21-р байрны орц засварлах		135.0	135.0
Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах		45.0	45.0
Сум дундын ойн ангид автомашины гарааш барих		185.0	185.0
Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих.		893.63	893.63
БТСГ-т шаардагдах тоног төхөөрөмж, хэрэглэл материал худалдан авах		230.5	230.5
Өрхийн тариалалтыг дэмжин хөгжүүлэх зорилгоор хүлэмж худалдан авах		200.0	200.0
Жаргалант угтах хаалгыг шинэчлэн засварлах	Жаргалант сумын хө.ор	130.0	130.0
Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах	Баян-Өндөр сумын хө.ор	2,550.0	2,550.0

Төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай хүргэх зорилгоор автомашины хэвийн үйл ажиллагааг хангах		120.0	120.0
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын дүрэмт хувцас худалдан авах		36.0	36.0
Хойд бүсийн хэмжээнд ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах		620.0	620.0
Ойн санг гэрээгээр эзэмшдэг 5 нөхөрлөлд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн хүлэмж олгох	Аймгийн БХСан	42.5	42.5
Нийт		14,396.7	10,574.2

Баян-өндөр сумын хөрөнгөөр орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний хүрээнд Төрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах боломжгүй, ашиг олох зорилготой 3,170.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Баян-Өндөр сумын Засаг даргын төсөвт хамаарахгүй “Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-т шилжүүлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад тарааж, ашиглуулж байна.

Энэ нь Төсвийн тухай 13.3¹, 13.3.2² заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3³-т заасныг зөрчсөн байх тул Баян-Өндөр сумын ИТХ, Засаг дарга нарт зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан зураг төсөвгүй 9 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орхон аймагт 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 8,585.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-г зураг төсөвгүй төлөвлөснөөс шалтгаалж хэрэгжээгүй байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- ✓ Хот тохижуулах газарт нийтийн тээврийн авто гарааш барих 3,500.0 сая төгрөг
- ✓ Говил багт УДДТ барих 1,830.0 сая төгрөг
- ✓ Спорт заалны барилга барих 2,000.0 төгрөг
- ✓ Шанд багийн халаалтын системийг хийн зуухаар шинэчлэх /17-р сургууль/ 89.03 сая төгрөг
- ✓ Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийн барилгын нэгдсэн бохирын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх /НҮБ-тай хамтран хэрэгжүүлэх/ 70.0 сая төгрөг

Аймгийн байгаль хамгаалах сан:

- ✓ Газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах 350.0 сая төгрөг

¹ “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”

² “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”

³ “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”

- ✓ Ус түгээх байрны цэвэр усны шугам барих ажил /Баянцагаан, Говил багт/ 541.87 сая төгрөг
- ✓ Байгаль орчныг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх зорилгоор камержуулалтын ажил зохион байгуулах зардал 75.0 сая төгрөг

Жаргалант сумын хөрөнгө оруулалт:

- ✓ Жаргалант угтах хаалгыг шинэчлэн засварлах 130.0 сая төгрөг

Баян-өндөр сумын хөрөнгө оруулалтаар Дизель түлшний үйлдвэр байгуулах 300.0 төгрөгийг баталсан ч баталгаажсан зураг төсөвгүй тул 2025 оны 07 сард хийгдсэн тодотголоор хасагдсан байна.

Жаргалант сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 02/10 дугаар тогтоолоор баталсан сумын хөрөнгөөр 2025 онд тодотгосон төсвийн санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалтад хөрөнгийн шинж чанаргүй, урсгал зардлын шинж чанартай 312.1 сая төгрөгийн 9 ТАХ-г баталжээ.

1.4. Хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн хуулийн зарим заалтуудтай нийцэхгүй байна.

Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар “Жаргалант угтах хаалгыг шинэчлэн засварлах”-д 130.0 сая төгрөг төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1⁴-т заалтыг зөрчсөн байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөсөн 8,007.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, байгаль хамгаалах сангаас 50.0 сая төгрөгийг 1 ТАХ, Жаргалант сумын хөрөнгөөр 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, Баян-Өндөр сумын хөрөнгөөр 3,170.0 сая төгрөгийн 2 ТАХ, Баян-өндөр сумын байгаль хамгаалах сангаас 100.0 сая төгрөгийн 1 ТАХ, нийт 11,502.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2⁵ заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- ✓ Уртын гол багт баригдаж байгаа 260 айлын 5 блок орон сууцны цогцолборын ажил 5,195.81 сая төгрөг,
- ✓ БОАЖГ-ын контор, орон сууцны инженерийн шугам сүлжээний ажил 128.9 сая төгрөг,
- ✓ Эрдэнэ баг. Эрчим хүчний өндөр хэмнэлтэд 37-н айлын Хайбрид гарден хотхоны гадна тохижилт хийх, инженерийн дэд бүтцийн ажил 1,987.8 сая төгрөг,
- ✓ Зэст баг. Орон сууцны 1-р хорооллын 21-р байрны орц засварлах 135.0 сая төгрөг,
- ✓ Өрхийн тариалалтыг дэмжин хөгжүүлэх зорилгоор хүлэмж худалдан авах 200.0 сая төгрөг,

⁴ “хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах”

⁵ “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ”

- ✓ Орон гэргүй иргэдэд гэр худалдан авах 360.0 сая төгрөг.

Аймгийн байгаль хамгаалах сан:

- ✓ Ойн санг гэрээгээр эзэмшдэг 5 нөхөрлөлд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн хүлэмж олгох 50.0 сая төгрөг

Жаргалант сумын хөрөнгө оруулалт:

- ✓ Гэр оронгүй зорилтот бүлгийн иргэдэд гэр олгох нэг удаагийн тусламжийн хүрээнд: Иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу гэр худалдан авах 20.0 сая төгрөг,
- ✓ Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу оёдлын машин худалдан авах 20.0 сая төгрөг,
- ✓ Өвлийн спортыг дэмжиж мөсөн талбай бий болгож, тэшүүр худалдан авах 20.0 сая төгрөг,
- ✓ Өвлийн спортыг дэмжиж цана худалдан авах 15.0 сая төгрөг,
- ✓ Гэр хорооллын айл өрхийг дэмжих ажлын хүрээнд: Тень худалдан авах 80.0 сая төгрөг,
- ✓ Гэр хорооллын айл өрхийг дэмжих ажлын хүрээнд: Бага оврын агаар сэлгэлт тоног төхөөрөмж худалдан авах 20.0 сая төгрөг.

Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалт:

- ✓ Хойд бүсийн өрхийн бичил бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах 2,550.0 сая төгрөг,
- ✓ Хойд бүсийн хэмжээнд ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмж худалдан авах 620.0 сая төгрөг.

Баян-Өндөр сумын байгаль хамгаалах сан:

- ✓ Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд шахмал түлш үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 100.0 сая төгрөг.

Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын дүрэмт хувцас худалдан авах 36.0 сая төгрөг баталж, хэрэгжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 8.1⁶, Төсвийн тухай хуулийн 4.1.24⁷ дах заалтыг зөрчсөн байна.

Аймгийн болон сумдын хөрөнгө оруулалтад тусгагдсан төсөл арга хэмжээнээс худалдан авах ажиллагааны үр дүнд 3,846.7 сая төгрөг, амжилтгүй болсон худалдан авах ажиллагаанаас 19,001.7 сая төгрөг нийт 22,848.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

⁶ “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”

⁷ “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”

Хүснэгт 8

ХАА-ны үр дүнд бий болсон хэмнэлтийн задаргаа

Захиалагч	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч шалгарсан		Хэмнэлт	Амжилтгүй болсон	
		Тоо	Гэрээний дүн		Тоо	Төсөвт өртөг
Аймгийн хө. Ор	66,899.7	126.0	64,325.0	2,574.8	23.0	18,911.7
Аймгийн БХСан	3,243.9	16.0	2,922.9	321.01	1.0	50.0
Аймгийн АЗСан	2,186.0	4.0	1,836.8	349.16	-	-
Жаргалант сумын хө.ор	2,030.4	20.0	1,668.9	361.52	2.0	40.0
Баян-Өндөр сумын хө.ор	7,640.1	26.0	7,399.9	240.22	-	-
Баян-Өндөр сумын БХСан	100.0	1.0	100.0	-	-	-
Нийт	82,100.2	193.0	78,253.5	3,846.7	26.0	19,001.7

Харин худалдан авах ажиллагааны үр дүнд үүссэн хэмнэлтийг болзошгүй аваарын зардалд гүйлгэн шилжүүлж, тодотголоор нийт 42,038.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт 9

Болзошгүй аваарын зардлын төсөв

Эх үүсвэр төрөл	Болзошгүй аваар		Зөрүү
	Анх баталсан	Тодотгосон төсөв	
Аймаг	2,817.89	44,708.63	(41,890.74)
Баян-Өндөр сум	300.00	500.00	(200.0)
Жаргалант сум	1,520.11	1,468.18	51.93
Нийт	4,638.00	46,676.81	(42,038.82)

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.2⁸, 13.1.3⁹; 13.1.4¹⁰, ТБОНӨХБАУХАТХ-ын 5.1¹¹ заалтыг зөрчсөн байна.

БҮЛЭГ 2 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭМНЭЛТИЙГ БОЛЗОШГҮЙ АВААРЫН ЗАРДАЛД ШИЛЖҮҮЛЭН ЗАРЦУУЛЖЭЭ.

2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд мэдээлсэн байна.

Орхон аймгийн худалдан авах ажиллагааны газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар 109,748.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 226 ТАХ тусгагдсан байна.

⁸ “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох”

⁹ “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”

¹⁰ “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”

¹¹ “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”

Хүснэгт 10

ХАА-ны хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөө

Захиалагч	ХАА-нд баримталсан журам									Нийт ТАХ ТОО	Нийт төсөвт өртөг
	НТШ	Төсөвт өртөг	ХА	Төсөвт өртөг	ШХА	Төсөвт өртөг	ЕГБ	Төсөвт өртөг			
Аймгийн хө. Ор	101	89,052.59	45	3690.28	5	108.6	1	360.0	152	93,211.45	
аймгийн БХСан	4	3,249.49	13	955.2	3	56.1	-	-	20	4,260.79	
аймгийн АЗСан	4	2,185.97	-	-	-	-	-	-	4	2,185.97	
Жаргалант сумын хө.ор	3	1,490.43	10	580	10	180.0	-	-	23	2,250.43	
Баян-Өндөр сумын хө.ор	9	6,521.46	16	1188.68	2	30.0	-	-	27	7,740.14	
Баян-Өндөр сумын БХСан	-	-	1	100	-	-	-	-	1	100.0	
Нийт	121	102,499.9	85	6,514.2	20	374.7	1	360.0	226	109,748.8	

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээр 78,253.5 сая төгрөгийн 193 гэрээ байгуулж, аймгийн хэмжээнд 3,846.7 сая төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 11

Худалдан авах ажиллагааны үр дүн

Захиалагч	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч шалгарсан		Хэмнэлт	Амжилтгүй болсон	
		Тоо	Гэрээний дүн		Тоо	Төсөвт өртөг
аймгийн хө. Ор	66,899.7	126.0	64,325.0	2,574.79	23.0	18,911.7
аймгийн БХСан	3,243.9	16.0	2,922.9	321.01	1.0	50.0
аймгийн АЗСан	2,186.0	4.0	1,836.8	349.16	-	-
Жаргалант сумын хө.ор	2,030.4	20.0	1,668.9	361.52	2.0	40.0
Баян-Өндөр сумын хө.ор	7,640.1	26.0	7,399.9	240.22	-	-
Баян-Өндөр сумын БХСан	100.0	1.0	100.0	-	-	-
Нийт	82,100.2	193.0	78,253.5	3,846.7	26.0	19,001.7

Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 19,001.7 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж дуусгаагүйгээс үүссэн хэмнэлт болон худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон 3,846.7 сая төгрөгийн хэмнэлтийг аймгийн болзошгүй аваарын зардалд шилжүүлж тодотголоор баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1¹², 13.1.2¹³, 13.1.3¹⁴, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

¹² “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”

¹³ “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох”

¹⁴ “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”

бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1¹⁵-т заасныг зөрчсөн байх тул аймгийн Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.


Үүнээс төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 8,496.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээний зураг төсөв батлагдаагүйгээс худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

“Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг зөрчин 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй өвлийн спортыг дэмжих төсөл, арга хэмжээний худалдан авалтыг 5 хувааж, шууд худалдан авалт хийхээр төлөвлөж, зохион байгуулсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Ус дулаан хуваарилах төвүүдийг үл хамаарах схемд шилжүүлэх иж бүрэн ялтсан бойлер суурилуулах 333.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний арга хэмжээг 14 хувааж нэг бүрийг 23.9 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Эдгээр нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.3¹⁶-т гэж заасныг зөрчсөн байна.

Болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэх зардлын хэмжээг сүүлийн 3 жилд 41,163.0 сая төгрөг буюу 1,260 дахин нэмэгдүүлж баталсан байна.

График 4 Болзошгүй аваарын зардлын өсөлт



2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/13 дугаар тогтоолоо зөвлөх үйлчилгээг шилжих үлдэгдлээр 1,661.9 сая төгрөг, шинээр 5,000.0 сая төгрөг, нийт 6,661.9 сая төгрөгөөр баталсныг 2025 оны 03/40 дугаар тогтоолоор тодотгож шилжих үлдэгдлээр 1,661.9 сая төгрөг, шинээр 6,000.0 сая төгрөг нийт 7,661.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөхдөө төсөл арга хэмжээний нэршлээр задалж баталдаггүй бөөн дүнгээр баталсан байна.

Хүснэгт 12

Зөвлөх үйлчилгээ

Зөвлөх үйлчилгээ	Анх баталсан	Тодотгол	Зөрүү
Шилжих	1,661.9	1,661.9	-

¹⁵ “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”

¹⁶ “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”

Шинэ	5,000.0	6,000.0	(1,000.0)
Нийт	6,661.9	7,661.9	(1,000.0)

Зөвлөх үйлчилгээгээр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад шилжих үлдэгдлээр хэрэгжих 271.2 сая төгрөгийн 10 ТАХ, шинээр хэрэгжих 6,463.7 сая төгрөгийн 134 ТАХ, нийт 6,734.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 144 ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгаснаас Худалдан авах ажиллагааны газраар дамжин худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 4,988.9 сая төгрөгийн өртөгтэй 69 ТАХ байна.

Зөвлөх үйлчилгээний 1,746.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 75 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5.1¹⁷, 9.1¹⁸, 10.3¹⁹, 44.1²⁰, 48.2.1²¹ заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Үйлчилгээ/ 20.0 сая төгрөг, Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Үйлчилгээ/ 100.0 сая төгрөг гэж заасныг тус тус зөрчсөн байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2.3. Худалдан авах ажиллагааны үр дүнд үүссэн хэмнэлтийг Болзошгүй аваарын зардалд шилжүүлэн худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Аймгийн төсөв 2024 оны 12 дугаар сард батлагдсаны дараа 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр аймгийн Засаг дарга, Хотын захирагчийн алба, ХАА-ны газар, “ХББЗА” ОНӨААТҮГ, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ын холбогдох албан тушаалтнууд хуралдаж төсөв батлагдсаны дагуу зураг төсөв ирүүлэх хугацааг тодорхой болгож, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах хугацааны талаар хуралдсан.

Хурлын үр дүнд Хотын захирагчийн алба 2025 оны 01 дүгээр сарын 15-ны дотор 36 ТАХ-ний зураг төсвийг, 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор 18 ТАХ-ний зураг төсвийг, 2025 оны 03 дугаар сарын 20-ны дотор 25 ТАХ-ний зураг төсвийг, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор автозамын 12 ТАХ-ний зураг төсвийг, 2025 оны 03 дугаар сарын 20-ны дотор 16 ТАХ-ний зураг төсвийг, “ХББЗА” ОНӨААТҮГ 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор 9 ТАХ-ны зураг төсвийг, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор 32 ТАХ-ний зураг төсвийг бэлтгэж ирүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дээрх хурлын тэмдэглэлээс үзэхэд хөрөнгө оруулалтын ажилд нийт 131 ТАХ-г зураг төсөвгүй төлөвлөж баталснаас хамаарч, худалдан авах ажиллагаа хугацаандаа

¹⁷ “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”

¹⁸ “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ”

¹⁹ “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”

²⁰ “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”

²¹ “худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах”

хэрэгжих боломжийг алдагдуулж, болзошгүй аваарын зардлаар бусдад давуу байдал олгох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3²², Төсвийн тухай хуулийн 29^{1.2.2}²³ заалтыг зөрчжээ.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад хэрэгжихээр төлөвлөсөн 4 ТАХ-г ОНХС-ийн эх үүсвэрээс давхардуулан баталсан байна. Үүнд:

1. Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Отгонбилэгийн гудамжны төв замаас 28, 34-р байрны авто зогсоол, авто замд их засварын ажлыг төсвийг 2 хувааж баталсан.
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Отгонбилэгийн гудамжны төв замаас 28,34-р байрны авто зогсоол, авто замд их засварын ажил хийх /нэмэлт ажил/ ОНХО-аас 39.3 сая төгрөг,
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Оюут баг. Отгонбилэгийн гудамжны төв замаас 28,34-р байрны авто зогсоол, авто замд их засварын ажил хийх ОНХС-аас 327.7 сая төгрөг,
2. Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уртын гол баг. 260 айлын орон сууцны 0.28 км авто зам шинээр барих ТАХ-ний эх үүсвэрийг ОНХС, ОНХО-т 2 хувааж баталсан
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уртын гол баг. 260 айлын орон сууцны 0.28 км авто зам шинээр барих ОНХО-аас 282.2 сая төгрөг,
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Уртын гол баг. 260 айлын орон сууцны 0.28 км авто зам шинээр барих ОНХС-аас 235.6 сая төгрөг,
3. Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих ТАХ-ний эх үүсвэрийг ОНХС, ОНХО-т 2 хувааж баталсан.
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих ОНХС-аас 893.6 сая төгрөг
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Чингэл багийн авто замын төгсгөлөөс Ёс заншлын өргөө хүртэлх 1км хатуу хучилттай авто зам шинээр барих ОНХС-аас 1,378.3 сая төгрөг,
4. Орхон аймаг. Баян-Өндөр сум. Баянцагаан баг. ПДУ хэсгийн 1.16 км хатуу хучилттай авто зам шинээр барих ТАХ-г 2 эх үүсвэрээс хуваасан.
 - ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Баянцагаан баг. ПДУ хэсгийн 1.16 км хатуу хучилттай авто зам шинээр барих. 1,260.1 сая төгрөг,

²² “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”

²³ “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”

- ✓ Орхон аймаг. Баян-Өндөр сум. Баянцагаан баг. ПДУ хэсгийн 1.16 км хатуу хучилттай авто зам шинээр барих ОНХС-аас 987.9 сая төгрөг,
- 5. Хурдан морь барианы тохижилт хийх
 - ✓ Хурдан морь барианы тохижилт хийх ТАХ-г аймгийн хөрөнгөөр 350.0 сая төгрөг,
 - ✓ Хурдан морь барианы тохижилт хийх ТАХ-г Жаргалант сумын хөрөнгө оруулалтад 100.0 сая төгрөг.

Жаргалант сумын болзошгүй аваарын зардлаар 1,111.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 22 ТАХ-г хэрэгжүүлснээс 286.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 11 төсөл арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусгагдаж, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдах боломжтой төсөл арга хэмжээг гүйцэтгүүлжээ.

Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дүгнэлтээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан “Мээжийн хишиг” ХХК-ыг аймгийн болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлэх 366.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.36²⁴, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1²⁵, 7.1.8²⁶, аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/717 дугаар захирамжаар баталсан “Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө зарцуулах журам”-ын 4.2²⁷-т заасныг зөрчсөн байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэсэн нийт 39,475.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 243 төсөл арга хэмжээнээс 102 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 31 төсөл арга хэмжээ нь шууд худалдан авалтаар, 110 төсөл арга хэмжээ нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар байжээ.

Эдгээр ажлууд нь ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаагүй, цахим сайтад байршаагүй хэрхэн сонгон шалгаруулалт явагддаг эсэх нь тодорхойгүй байдлаар гүйцэтгэгчийг сонгосон байна.

Хүснэгт 13

Болзошгүй аваарын зардлын гүйцэтгэл

ХАА-ны төрөл	Аймаг		Баян-Өндөр		Жаргалант		Нийт	
НТШ	97	31,351.0	12	112.8	1	612.7	110	32,076.4

²⁴ “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”

²⁵ Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ:

²⁶ “тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй”

²⁷ “Улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Хотын Захирагчийн албанаас ажил гүйцэтгэх компанийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж ажил гүйцэтгэх гэрээний төслийг боловсруулан, Хууль эрх зүйн хэлтсээр хянуулж аймгийн Засаг дарга батлан хүчин төгөлдөр болсноор, ажлын гүйцэтгэлд зураг төсөл зохиогч болон Хотын захирагчийн албанаас хяналт тавьж ажиллана”

ШХА	19	179.4	0	0.0	12	136.5	31	315.9
ХА	94	6,469.3	2	252.1	6	361.9	102	7,083.4
Нийт	210	37,999.7	14	364.9	19	1,111.1	243	39,475.7

Хотын захирагчийн алба Болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэх ТАХ-г 2-3 байгууллагад үнийн санал ирүүлэх хүсэлт хүргүүлж, ТБОНХӨБАҮХАТХ-ийн “Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах” ажлыг хийхдээ иж бүрэн баримтжуулахгүй гүйцэтгэгчийг сонгодог давуу эрхтэй байгууллага болсон байна.

Болзошгүй аваарын зардал нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.1.1-т “болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг арилгах”, 9.1.2-т “барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг улс, орон нутгийн төсөвт байгууллага, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах”; 9.1.3-т “гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх”; 9.1.4-т “гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх”; 9.1.5-т “хөгжлийн бодлогын төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох” зорилготой байтал аваарын нөхцөл байдал нэрийдлээр ХАА амжилтгүй болсон ТАХ-үүдийг болзошгүй аваарын зардалд шилжүүлж, гүйцэтгэгчийг хууль журмын дагуу зохион байгуулахгүй байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/69 дүгээр захирамжаар баталсан “Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө гаргах” журмыг 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/717 дугаар захирамжаар “Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө гаргах журам” болгон шинэчлэн баталсан.

ТБОНХӨБАҮХАТХ-ийн 35.1.2²⁸ дах заалтад зааснаар онц байдал гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас худалдан авах ажиллагаа зохион байгуулах боломжгүй бол бараа ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулах гэсэн заалттай боловч хэрэгжилтийг хангаагүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулах боломжтой ТАХ-г болзошгүй аваарын зардалд шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал:

- Бүрэнбүст баг УДТТ 5-4 дулаан, цэвэр усны шугам шинэчлэх ажил,
- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын засварын ажил,
- Сум дундын ойн ангийн барилгын засварын ажил,
- Улсын бүртгэлийн хэлтсийн архивын өрөөний засвар,
- Орон сууцны байруудын цахилгаан шат шинэчлэлт хийх ажил.

Иймд аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг болзошгүй аваарын зардалд шилжүүлэн зарцуулахгүй байх тухай зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Оюу цэцэрлэгийн гадна цахилгааны ажил шинээр хийх 26.5 сая төгрөгөөр тусгагдаж 6 удаа харьцуулалтын аргаар ХАА-г зохион байгуулсан боловч оролцогч

²⁸ “онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй”

байхгүйн улмаас амжилтгүй болж болзошгүй аваарын зардлаар гүйцэтгүүлэхдээ төсөвт өртгийг 4.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 30.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн.

Бүрэнбүст баг УДТТ 5-4 дулаан, цэвэр усны шугам шинэчлэх 277.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г 2 удаа НТШ-аар зохион байгуулж, 1 байгууллага үнийн санал ирүүлсэн боловч хүний нөөцийг цахим системд санал болгоогүй, ажилчдын ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлээгүй, ажилласан жилийг нотлох баримт ирүүлээгүй, эзэмшлийн тоног төхөөрөмжийг цахим системээр санал болгоогүй, автокраны магадлалын дүгнэлт ирүүлээгүй тул тендерээс татгалзаж, болзошгүй аваарын зардлаас 223.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхдээ БЗА-3.3 “ус хангамж ариутгах татуургын” тусгай зөвшөөрөлгүй байгууллагаар гүйцэтгүүлжээ.

Орон сууцны байруудын цахилгаан шат шинэчлэлт хийх 3,200.0 сая төгрөгийн өртөгтэй ТАХ-ний ХАА-г 2 удаа зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сард нээсэн тендерт 6 байгууллага үнийн санал ирүүлсэн ч техникийн чадавхын туршлагыг хангаагүй тул амжилтгүй болсон.

Дээрх 6 байгууллагыг тендерт оролцохдоо ирүүлсэн үнийн саналыг техникийн тодорхойлолтод тусгагдсан цахилгаан шат бүрээр дэлгэрэнгүй тусгагдсан байдлыг дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 14

Цахилгаан шатны үнийн санал

Байрны давхар	Ширхэг	Би эл ти бриллиант ХХК	Браун элеватор Монголия ХХК	Гэрэлт урсгал ХХК	Оакс экспресс ХХК	Өвөр Булган Уул ХХК	Хан хөгшин трейдинг ХХК
9 давхар /9 зогсоолтой /	13	154.7	158.2	149.8	166.3	149.8	156.1
12 давхар 13 зогсоолтой	4	169.6	181.0	164.4	166.3	164.4	164.2
10 давхар /10 зогсоолтой/	1	167.6	198.2	169.4	166.3	169.4	166.6
10 давхар /11 зогсоолтой/	1	170.4	211.4	176.2	166.3	176.2	167.3
Ирүүлсэн үнийн санал	19	3,027.5	3,190.0	2,951.2	3,160.3	2,951.2	3,020.0

Аймгийн болзошгүй аваарын зардлаар “Браун элеватор Монголия” ХХК-ийн хэрэгжүүлсэн 8 цахилгаан шатны ажлыг зах зээлийн ханшнаас тус бүрийг нь 55.1 сая төгрөгийн өндөр үнэтэйгээр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1²⁹, 6.6.3³⁰, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5³¹-д заасныг зөрчсөн байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж байна.

²⁹ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

³⁰ “төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх”

³¹ “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”

Төсвийн хөрөнгөөр 2025 онд төрийн байгууллагын хэрэгцээнд тээврийн хэрэгсэл худалдан авахад 383.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 378.8 сая төгрөгийн 6 тээврийн хэрэгслийг худалдан авсан байна.

Хүснэгт 15 Тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй жагсаалт

Эх үүсвэр	ТАХ-ний нэр	Машины загвар	Худалдан авсан үнэ	Зах зээлийн үнэ	Үнэ
Баян-Өндөр сумын хөр.ор	Төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай хүргэх зорилгоор автомашины хэвийн үйл ажиллагааг хангах	Тоёота кроун	53.0	48.5	4.5
		Тоёота альфард	66.0	51.0	15.0
Аймгийн хө.ор	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай автомашин	Тоёота приус-30	25.0	23.8	1.2
	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газарт шаардлагатай автомашин худалдан авах	Хьюндай Стариа	141.0	91.0	50.0
	Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах	Тоёота альфард	45.0	45.0	-
Жаргалант сум хө.ор	Сумын цагдаагийн хэсэгт туулах чадвартай машин худалдан авах	Тоёота хариер	48.8	43.0	5.8
Нийт			378.8	302.3	76.51

Худалдан авсан үнийг зах зээлийн үнэтэй харьцуулан үзэхэд 302.3 сая төгрөг, зах зээлийн үнээс 76.5 сая төгрөгийн илүү үнэтэй байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газарт шаардлагатай автомашин худалдан авах Хьюндай Стариа тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтод хөдөлгүүрийн багтаамжийг 3,000-3,500сс байхаар заасан боловч нийлүүлэхдээ 2,188сс багтаамжтай тээврийн хэрэгслийг хүлээн авсан байна.

2.4. Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хуулийн хугацаанд хянаж шийдвэрлэжээ.

Аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний 109,748.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 226 ТАХ-ний худалдан авах ажиллагаанаас 29 гомдол гарснаас 2 нь Монополын эсрэг газарт, 27 нь Сангийн яаманд гомдол гаргажээ.

Хүснэгт 16 Гомдол, шийдвэрлэлтийн байдал

№	Эх үүсвэрийн төрөл	Сангийн яам	Монополын эсрэг газар	Гомдол шийдвэрлэлт	
				Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй
1	Аймгийн Хөр. Ор	20	2	13	8
2	Аймгийн БХСан	1			1
3	Баян-Өндөр сумын Хө.Ор	3		2	1
4	Жаргалант сумын Хө.Ор	3		3	
Нийт тоо		27	2	18	10

Гомдол гаргасан 29 өргөдлөөс 19 гомдлыг захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 10 гомдлыг захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж шийдвэрлэжээ.

Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж үзсэн 10 ТАХ-г дахин үнэлгээ хийж бүх тендерээс татгалзаж, дахин зарласан байна.

БҮЛЭГ 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ АЛДАГДСАН БАЙНА.

3.1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгосон.

Орон нутгийн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нийт гүйцэтгэлд 79,240.0 сая төгрөгийг 6 эх үүсвэрээс олгосон байна.

Хүснэгт 17

Санхүүжилт олгосон мэдээлэл

Эх үүсвэр	Гүйцэтгэгчид олгосон	Магадлашгүй ажил	Захиалагчийн хяналт	Зохиогчийн хяналт	Барьцаа 5%	Алданги	Нийт
Аймгийн ОНХО	62,910.6	304.1	78.9	544.5	672.1	15.7	64,526.0
АЗСан	2,329.0	-	24.0	-	78.8	-	2,431.7
ЭТСан	-	-	-	-	-	-	-
Аймгийн БХС	2,396.4	7.7	-	-	2.5	-	2,406.6
БӨ ОНХО	4,184.7	6.2	-	9.3	66.4	0.7	4,267.2
БӨ БХС	878.0	12.5	-	-	24.8	-	915.3
Жар ОНХО	4,552.5	8.7	-	-	131.9	-	4,693.2
Нийт	77,251.2	339.2	102.8	553.8	976.6	16.4	79,240.0

Эрдэнэт сангийн эх үүсвэрээс 4 ТАХ-нд 3,451.7 сая төгрөг олгохоор батлагдсан боловч санхүүжилтийн гүйцэтгэл тайлант онд гараагүй байна.

Аймгийн хэмжээнд болзошгүй аваарын зардалд 46,676.8 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 39,485.1 сая төгрөгийн 251 ТАХ-ний гэрээ байгуулж, 23,712.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 18

Болзошгүй аваарын зардал Зөвлөх үйлчилгээний олгосон санхүүжилт

Эх үүсвэр төрөл	Болзошгүй аваар				Зөвлөх үйлчилгээ			
	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Олгоогүй санхүүжилт	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Олгоогүй санхүүжилт
Аймаг	210	37,999.7	22,364.5	15,635.2	136	4,827.6	1,207.4	3,620.2
Баян-Өндөр сум	19	374.3	367.6	6.7	-	-	-	-
Жаргалант сум	22	1,111.1	980.7	130.4	1	405.0	100.0	305.0
Нийт	251	39,485.1	23,712.8	15,772.3	137.0	5,232.6	1,307.4	3,925.2

Зөвлөх үйлчилгээний зардалд нийт 7,661.9 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 5,232.6 сая төгрөгийн 137 ТАХ-ний гэрээ байгуулж, 1,307.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Санхүүжилттэй холбоотой дараах зөрчилд аймгийн засаг даргад 72.1 сая төгрөгийн албан шаардлага, анхан шатны баримт материал ирүүлээгүйтэй холбоотой хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Тайлант онд хийгдсэн 5 ТАХ-ээс чанарын баталгаа 72.1 сая төгрөгийн чанарын баталгаа суутгаагүй, гүйцэтгэгчид санхүүжилтийг бүтэн олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.
- Санхүүжилтийн мэдэгдэл олгосон анхан шатны баримтаас 2025 оны 9,10,11,12 сарын 3,697.9 сая төгрөгийн 29 ТАХ-ний анхан шатны баримтыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1³² заасныг зөрчсөн тул 42.1³³-т заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Баян-Өндөр сумын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой 1.9 сая төгрөгийн хугацааны алдангийн 2 төлбөрийн акт, 135.7 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2 ТАХ /Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газарт шаардлагатай автомашин худалдан авах, "Оюу цэцэрлэгийн гадна тохижилтын ажил"-ний хэрэгжилт гэрээнд заасан хугацаанаас хоцорч дууссан байхад хугацааны алданги 1.9 сая төгрөгийг гүйцэтгэгчээс суутгаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 5 ТАХ-ээс 56.7 сая төгрөгийн чанарын баталгааг суутгаагүй, гүйцэтгэгчид санхүүжилтийг бүтэн олгосон зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд батлагдсан "Их залуу багт камержуулалт" төсөл арга хэмжээний санхүүжилт 49.8 сая төгрөгийг Баян-Өндөр сумын Засаг даргын захирамжаар болзошгүй аваарын зардлаас зарцуулсан.
- Баян-өндөр сумын засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/156 тоот захирамжаар Болзошгүй аваарын зардлаар хийгдсэн үерийн далан нөхөн сэргээх, суваг шуудуу засварлах ажлын 29.12 сая төгрөгийн шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

³² "шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах"

³³ "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"

Жаргалант сумын болзошгүй аваарын зардалд илэрсэн 1,233.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлсэн “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК-ийн их засварын ажлын урьдчилгаа санхүүжилтийн 60 хувийг гүйцэтгэгчид шилжүүлэх байтал 122.5 сая төгрөгийн санхүүжилтийг “Юникорн Менежмент” ХХК-д илүү олгосон байна.
- Жаргалант ус дулаан түгээх сүлжээ-д хийгдэх их засварын ажил 612.7 сая төгрөгийн гэрээтэй ажил нь батлагдсан зураг төсөвгүй, хяналт хэрэгжүүлсэн анхан шатны баримтгүй, барилгын болон бусад шаардлагатай тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй.
- Болзошгүй аваарын зардлаар хэрэгжүүлсэн 94.3 сая төгрөгийн өртөгтэй 7 төсөл, арга хэмжээнд сумын Засаг даргын захирамж гаргаагүй.
- Улсын байцаагчийн дүгнэлт гараагүй байхад 403.6 сая төгрөгийн өртөгтэй 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон байна

Аймгийн болзошгүй аваарын зардлаар санхүүжүүлсэн төсөл арга хэмжээнүүдэд нийтлэг дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Гүйцэтгэгчийн үнийн санал гэрээ байгуулах эрх олгох албан бичгийн дараа хугацаатай.
- Гүйцэтгэгч байгууллагын татвар нийгмийн даатгалын тодорхойлолт гэрээний хугацаа дуусаж байхад ирүүлсэн.
- Гүйцэтгэгчээс ирүүлсэн албан бичгүүд он саргүй.
- Улсын байцаагчийн дүгнэлтгүй.
- Улсын байцаагчийн дүгнэлт нь хугацааны хувьд зөрүүтэй.
- Гэрээ дүгнэх үйл ажиллагаа он саргүй.
- Гүйцэтгэгч байгууллага ажлаа хүлээлгэж өгөх тухай ирүүлсэн албан бичиг байхгүй.
- Гүйцэтгэгчийн комисс ажиллуулах хүсэлт албан бичиг байхгүй

Иймд анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангасны дараа гүйцэтгэлийн санхүүжилтийг олгож байх талаар аймгийн Засаг дарга, Хотын захирагчийн албанд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй баталж, худалдан авах ажиллагааг оройтож зохион байгуулснаас шалтгаалж хугацаандаа хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнээс 71,736.8 сая төгрөгийн 230 ТАХ 100% хэрэгжиж гэрээг дүгнэсэн байна.

Хүснэгт 19

ТАХ-ний хэрэгжилтийн байдал

Эх үүсвэр	0%		20%-50%		51%-80%		81%-99%		100%	
	ТАХ тоо	Гэрээний дүн	ТАХ тоо	Гэрээний дүн	ТАХ тоо	Гэрээний дүн	ТАХ тоо	Гэрээний дүн	ТАХ тоо	Гэрээний дүн
Аймаг ОНХО	30	-	2	2,272.6	15	47,198.5	7	5,700.5	148	57,427.9
АЗСан	-	-					3	1,576.0	2	1,196.1
БХСан	5	-			4	2,260.7	-	-	19	1,769.0
Баян-Өндөр сум ОНХО	1	-	2	6,046.1	-	-	-	-	28	6,059.9
Жаргалант ОНХО	4	-	1	405.0	-	-	1	21.6	33	5,283.9
Нийт	40	-	5	8,723.7	19	49,459.2	11	7,298.1	230	71,736.8

Орхон аймгийн төсвийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын 26 ТАХ, Баян-Өндөр сумын төсвийн хөрөнгө оруулалтын 2 ТАХ-д гэрээ сунгалт хийгдсэн байна.

Гэрээ сунгалтыг дараах шалтгаанаар сунгасан байна. Үүнд:

- Цаг уурын нөхцөл байдлаас хамаарч 3 ТАХ,
- Санхүүжилтээс хамаарч 1 ТАХ,
- Зураг төсвөөс шалтгаалсан 6 ТАХ,
- Оршин суугчдын хүсэлтээр нэмэлт ажил хийгдэж гэрээ сунгагдсан 2 ТАХ,
- Захиалагч байгууллага хил гаальтай бараа нийлүүлэлт удааширсан 5 ТАХ,
- Гэрээ сунгахдаа хугацааны алданги тооцуулсан 2 ТАХ.

Хил гааль хаасан, бороо их орсон, зураг төсөвт өөрчлөлт орсон зэрэг шалтгаануудаар гэрээг сунгасан нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний 2.9³⁴, 2.9.1³⁵, 2.9.2³⁶, 2.9.3³⁷, 2.9.4³⁸-т заасантай нийцэхгүй байна.

Гэрээ сунгах хурлын комиссын даргыг 4 албан хаагч хийж байгаагаас шалтгаалж, гэрээ сунгалтад харилцан адилгүй шийдвэр гаргасан байна.

Иймд гэрээ сунгах үйл ажиллагаанд захиалагчийг төлөөлж, захиалагчийн хяналтыг төлөөлж, төсөв санхүүг төлөөлөх албан тушаалтныг томилж байгуулсан гэрээний зүйл заалтад нийцүүлэн гэрээг сунгаж байх хэрэгтэй байна.

3.3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 71,736.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 230 ТАХ-г хүлээн авсан байна.

³⁴ Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно

³⁵ “ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн”

³⁶ “холбогдох хууль, журам стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал”

³⁷ “Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй ”

³⁸ “Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын цаг хугацаанд нөлөөлсөн”

Тайлант онд 71,736.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 230 ТАХ бүрэн хэрэгжиж дууссанаас 8,097.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 8,097.1 сая төгрөг нь тоног төхөөрөмж худалдан авах ТАХ байна.

Гүйцэтгэгч байгууллага тоног төхөөрөмж хүлээлгэж өгөх хүсэлт өгсний дагуу Орон нутгийн өмчийн газар болон ашиглагч байгууллага техникийн тодорхойлолтын дагуу, тоо ширхэг, иж бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авдаг байна.

Ашиглагч байгууллага хүлээн авсан талаарх мэдээллийг Орон нутгийн өмчийн газарт ирүүлсний дараа гэрээ дүгнэх хурлыг хийж байгууллагын санхүүжилтийг олгох баримт бичгийг гүйцэтгэгч байгууллага аймгийн СТСХ-т ирүүлдэг байна.

Харин ажил хүлээлгэж өгөх хүсэлтийг гүйцэтгэгч байгууллага Хотын захирагчийн албанд хүргүүлсний дараа ажил хүлээн авах комисс Хотын захирагчийн албаны ерөнхий инженер, хяналтын инженер, аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн хариуцсан мэргэжилтэн, ашиглагч байгууллага, орон нутгийн өмчийн газар, архивын хэлтэс гэсэн бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж хүлээн авсан байна.

Хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэлийн баримтыг 4% үйлдэж, 1% нь архивын хэлтэс, 1% нь санхүүжилтийн баримтад, 1% нь Хотын захирагчийн алба, 1% нь гүйцэтгэгч байгууллагад үлддэг байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн үйл явц, статистик тоон үзүүлэлтүүдийг хянах зорилгоор Зөвлөх үйлчилгээний зардлын задаргаанд “Эрдэнэт И-оффис бараа ажил үйлчилгээ худалдан авалтын бүртгэл гүйцэтгэл, хяналтын цахим систем” 95.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг “Анарсистем” ХХК-аар 2025 оны 04 дүгээр сарын 17-оос 08 дугаар сарын 22-ны өдрийн хооронд 91.9 сая төгрөгийн гэрээг байгуулан хэрэгжүүлжээ.

Хөрөнгө оруулалт ТАХ-ний гүйцэтгэл, хяналтын системийг шинээр нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

Жаргалант ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-д хийгдэх их засварын ажил 612.7 сая төгрөгийн гэрээтэй ажил нь батлагдсан зураг төсөвгүй, хяналт хэрэгжүүлсэн анхан шатны баримтгүй ТАХ-г хэрэгжүүлж ашиглалт бүрэн дуусгаж оруулаагүй байдалтай байна.

Жаргалант сумын болзошгүй аваарын зардлаас зарцуулсан 305.8 сая төгрөгийн гэрээтэй 7 ТАХ-г зураг төсөвгүй, хэрхэн гэрээний дүнг тодорхойлсон нь тодорхойгүй, хяналтгүй гүйцэтгэсэн.

Аймгийн төсвийн хөрөнгөөр 0.4 кВ-ын 3х50+1х54 СИП утас нэмж татаж барих ажилд 2,166.2 сая төгрөг батлагдаж 1 удаа тендер зохион байгуулсан боловч 1,920.5 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн байгууллага нь ажил гүйцэтгэх хүний нөөц шаардлага хангаагүй тул амжилтгүй болсон.

Тус ажлыг болзошгүй аваарын зардлаар гүйцэтгэхдээ олон жижиг ТАХ болгон нэршлийг өөрчлөн нийт 5,277.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 25 ТАХ-ээс 815.0 сая төгрөгийн 4 ТАХ-нь Эрчим хүчний яамнаас олгогдсон тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Зөвшөөрлийн тухай хуулийн 14-т “Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно”, 14.4³⁹-т заасныг зөрчсөн байна.

3.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-г 124,790.0 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын бүртгэл тайланд тусгасан байна.

Харин Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-нд 18,753.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20 ТАХ-г бүртгэл тайланд тусгуулах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн боловч шийдвэр ирээгүй бүртгээгүй байна.

Хүснэгт 20

ТАХ-ний бүртгэл

Байгууллагын төрөл	ТАХ-ний тоо	Ашиглагч байгууллага	Мөнгөн дүн
Төрийн байгууллага	133	138	95,609.1
ОНӨХК, ТӨХК, ААТҮГ	65	65	24,666.7
Боловсролын байгууллага	20	22	2,987.5
Эрүүл мэндийн байгууллага	6	6	951.5
Хувийн СӨХ	3	3	575.2
Нийт	227	234	124,790.0

Хорих ангийн дээврийн засвар хийхэд шаардлагатай материал худалдан авах 111.02 сая төгрөг, Согоот баг.Баян-Өндөр сумын 14-р сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах 342.9 сая төгрөг нь урсгал зардлын шинж чанартай тул шууд зардлаар тайлагнажээ.

Жаргалант сумын хөрөнгө оруулалтад тусгагдсан 176.7 сая төгрөгийн 8 ТАХ нь урсгал зардлын шинж чанартай ТАХ-г хэрэгжүүлж санхүүжилт гарсныг зардлаар бүртгэжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ээс 5,010.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-ний санхүүжилт олгогдсон ч бүртгэлгүй орхигдсон байна. Үүнд:

- Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг халаалтын нүүрстөрөгч багатай эх үүсвэртэй холбох 750.0 сая төгрөгийн гэрээтэй 592.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.
- Ус дулаан хуваарилах төвүүдийг үл хамаарах схемд шилжүүлэх иж бүрэн ялтсан бойлер суурилуулах 4,131.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3,585.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.
- Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд ойн мэргэжлийн байгууллагаар ойжуулалт хийх 129.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 103.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.

³⁹ “0.4-15кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”

Дээрх зөрчилд Орон нутгийн өмчийн газарт зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3.5. Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх онд хийгдсэн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт аудитаар 163.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 810.2 сая төгрөгийн 9 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлж, аймгийн Засаг даргад 3, ХАА-ны газарт 2 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг дахин үнэлэхэд:

- ✓ 163.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт төсөвт бүрэн төвлөрсөн.
- ✓ Гэр бүлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн төв ажиллуулах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зорилгоор "Эрдэнэт академи" НҮТББ-тай 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 49/23 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээ дүгнэлгүй 40.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй тул хариуцсан ажилтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан.
- ✓ Өмнөх аудитаар санхүүжилт, төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 810.2 сая төгрөгийн 9 албан шаардлагыг аймгийн ИТХ, Засаг дарга, Баян-Өндөр сумын засаг дарга нарт хүргүүлсэн зураг төсөвгүй төсөл арга хэмжээтэй холбоотой 3 албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй, 2025 онд батлагдсан зураг төсөвгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ төлөвлөж, ИТХ нь шаардлага хангаагүй төсвийг баталсаар байна.
- ✓ Өмнөх онд хийгдсэн аудитаар аймгийн засаг даргад 3 зөвлөмж, Худалдан авах ажиллагааны газарт 2 зөвлөмж хүргүүлснийг хянахад хэрэгжилт хангагдсан байна.

ДҮГНЭЛТ:

- ✓ *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Орхон аймгийн хөгжлийн төлөвлөгөө, засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэж байна.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэдийн оролцоог хангаагүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл арга хэмжээг төлөвлөжээ.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан зураг төсөвгүй 9 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн хуулийн зарим заалтуудтай нийцэхгүй байна.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд мэдээлсэн байна.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна.*
- ✓ *Худалдан авах ажиллагааны үр дүнд үүссэн хэмнэлтийг Болзошгүй аваарын зардалд шилжүүлэн худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.*
- ✓ *Сангийн яам тендер шалгаруулалтад гаргасан гомдлыг хуулийн хугацаанд хянаж шийдвэрлэжээ.*
- ✓ *Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгосон.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй баталж, худалдан авах ажиллагааг оройтож зохион байгуулснаас шалтгаалж хугацаандаа хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.*
- ✓ *Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 71,736.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 230 ТАХ-г хүлээн авсан байна.*
- ✓ *Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.*
- ✓ *Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.*

ЗӨВЛӨМЖ:**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛД:**

- Төсвийн хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний төсвийг бөөн дүнгээр батлахгүй байх.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Зөвлөх үйлчилгээний төсвийг төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөж байх.
- Гэрээ сунгах үйл ажиллагаанд оролцох албан тушаалтныг томилох.

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжтой төсөл арга хэмжээг болзошгүй аваарын зардалд шилжүүлэн хэрэгжүүлэхгүй байх.

ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНД:

- Тусгай зөвшөөрөлгүй компаниар цахилгаан, шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлэхгүй байх.

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал:



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2026. 05. 08 № 01/1878
танай _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын
нийцлийн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Аудитын дүгнэлтэд хүргүүлэх саналгүй
болно.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБЯАР

6126091070



ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Ш.Отгонбилэгийн гудамж, Оюут Баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025
Утас/факс: (976) 70350965
Цахим шуудан: buzdtg@bayanundur.mn
Цахим хуудас: www.bayanundur.mn

2026.05.08 № 01/954
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



Б.МӨНХБАЯР

61260700612



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, Жаргалант баг,
Жаргалант сум, Орхон аймаг, 61015
Утас: (976) 7039 7214
Цахим шуудан: info@jargalant.or.gov.mn
Цахим хуудас: <https://jargalant.or.gov.mn>

2026.05.08 № 02/399
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  ТЛХАГВАЦЭРЭН



0126010377



**ЭРДЭНЭТ ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЛБА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 8012

Цахим шуудан: erdenethot.hza@gmail.com

2026.05.17 № 389

танай _____ -ны № _____ -г

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын тайлантай танилцлаа, санал дүгнэлт байхгүй.
Цаашид зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллах болно



Эрдэнэт хотын захирагчийн алба
Захиргаа
Дарга
Бүрнэбадар Одгэрэл
2026.05.17 11:31:53